



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.Сүм хийд, лам санваартны нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу төлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР